

Амьтдын тухай үлгэрүүд-3

ЧОНЫН ЗӨРҮҮД ЗАН



Zambak
YAYINLARI



Чонын зөрүүд зан
Эрхлэн гаргасан: Эмпати-Ертөнц ХХК

© Энэхүү бүтээлийн эрх нь Монгол Улсын Зохиогчийн Эрхийн тухай хуулиар хамгаалагдсан болно. Бүтээлийг цахим хэлбэрээр түгээх эрхийг bookstore.mn цахим хуудас эзэмших бөгөөд зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн хувилах болон бусад ямар нэгэн хэлбэрээр олшруулах, ашиглахыг хориглоно.

www.bookstore.mn

Чонын зөрүүд зан



Чоно хэдэн өдөр хоолойгоороо нэг ч үмх мах давуулаагүй учир ходоод нь тэвчихийн аргагүй хонхолзож байлаа.

Чоно:

-Зөөлөн сайхан хурганы мах байсан ч болоосой. Ходоодоо баярлуулж нэг сайн идэх юмсан гэж үглэж байлаа. Яг энэ үед урд уулын энгэрээр хонин сүрэг бэлчиж байхыг олж харжээ. Шууд л хонин сүргийн зүг гүйж очив. Сүрэгт ойртон очоод юу харсан гэж санана!



Хоёр хоточ нохой сүрэгтэй цуг явж байв. Хонин сүргээс хурга хулгайлах нь тун хэцүү болов.

Чоно арайхийж нохдоос зугатаж гэнэ. Өлсгөлөн хэвээрээ эргээд явжээ. Гэвч хурганы зөөлөн мах санаанаас нь огт гарахгүй л байлаа.

-Ямар нэгэн арга хэрэглээд хэдэн хурга заавал барьж иднэ дээ гэж бодов.

Маргааш нь дахиад нэг туршаад үзье гэж шийдлээ.



Өглөө босоод шууд хонин сүргийн зүг замд гарчээ. Харин дахиад л хоточ нохдод хөөгджээ.

-Би хөгширсөн юм байхдаа. Нохдын элэг доог болж байна даа. Бүхэл бүтэн гурван өдөр огт хоол идэлгүй явсан чоно байдаг гэж би огт сонсоогүй юм байна гэсээр зугтжээ.

Ер нь ингээд зугатаад байж болохгүй юм байна гэдгийг ойлгосон чоно:



-Нэг төлөвлөгөө зохиох хэрэгтэй байна. Нохдыг намайг харахаас нь өмнө чимээгүйхэн очоод нэг хурга аваад зугатъя.

Чадахгүй юм бол чоно гэж явахын хэрэг алга гэж өөртөө тангараглажээ. Ингээд шөнөжингөө хар санаат төлөвлөгөөгөө зохиож хоножээ. “Юу хийх вэ?” гэж бодож байтал гэнэт нэг сайхан санаа төржээ.

-Би хонин сүргийн дотор орж хурга барьж идэхийг хүсч байгаа. Тэгвэл тэдний дунд орохын тулд хоньтой адилхан харагдах ёстой гэж өөртэйгээ ярьж гэнэ.

Чоно өглөө болохыг тэсэн ядан хүлээжээ. Хонин сүргээс заавал хурга барьж иднэ гэж

улайран боджээ. Өөр арга байхгүй байлаа.

Хонин сүргээс нэг, хоёр хурга барина гэж төлөвлөж байлаа. Чоно хонины арьс олж аваад нуруун дээрээ тохов. Ингээд нөгөө чоно маань хонь болж хувирав.



Хонин сүрэг дунд сэмээрхэн яваад орчихов.

Өлссөндөө болоод бүх сүргийг идчихмээр санагдаж байлаа.



Гэхдээ тэвчих хэрэгтэй байв. Эхлээд хоёр хургыг хуурч сүргээс таслан холдуулах хэрэгтэй байлаа. Нүдэлж авсан хоёр хурганы дэргэд очин:

-Найзаа та нарын идэж байгаа энэ өвсийг өвс гэдэггүй юм даа.



Миний мэддэг нэг бэлчээр байдаг юм. Ямар их өвс ногоотой гэж санана. Өвс нь хонь далд орохоор тийм өндөр ургасан гэж хэлээд хоёр хургыг мэхэлжээ.

Хоёр хурга чоныг даган тэрхүү бэлчээр тийш явах болов. Чоно хургануудад чимээгүй байхыг сануулжээ. Эс тэгвээс бусад хурганууд мэдчихээд дагаж магадгүй гэж анхааруулсан байлаа. Харин үнэн хэрэгтээ чоно нохдын анхаарлыг татахгүй гэсэндээ хоёр хурганд ийнхүү сануулсан байжээ.



Хэсэг явсны дараа нэг хурга нь чонын нөмөрсөн арьсан доороос цухуйж байгаа сүүлийг нь харчихав. Хонины арьс нөмөрсөн чоно болохыг нь мэдчихжээ. Тэгээд хурга чононоос ингэж асуув:

-Ах минь нөгөө бэлчээр чинь хаана байгаа юм бэ? Бид сүргээсээ нэлээд холдчихлоо шүү дээ!




Чоно:

-Жаахан тэвчээрэй, тун удахгүй хүрнэ

гэжээ.

Чоно тэднийг идэхээр авч явж байгааг мэдсэн хурга өрөвдөлтэй гэгч майлав. Тэгээд эргээд сүрэг рүүгээ зугтав. Хурганы эргээд гүйхийг харсан чоно: “Нэгийг нь алдсан ч гэсэн ядаж нөгөөг нь алдахгүй шүү” гэж бодон үлдсэн хурган дээр үсрэн очив.



Яг энэ мөчид хүзүүн дээрээс нь нохой зуухыг мэдрэв. Нохойн шүднээс айсан чоно хургыг барих нь битгий хэл арай ядан амиа авран зугатав.

Чоно ухаангүй зугатаж явахдаа өмнөө байсан хадан хясаанаас өнхрөн доош унажээ.

Аз болж амиа алдсангүй. Гэвч бүх бие нь бэртжээ.



- Ухаангүй тэнэг толгой! Яах гэж хонин сүрэгт санаархав даа. Нохдыг сонор соргог гэдгийг мэдсээр байж бүтэхгүй зүйлийн төлөө ингэж зөрүүдлэн зүтгэж байж амиа алдах дөхлөө шүү. Үүнээс хойш хэрэндээ тохируулж ангаа сонгож байхгүй бол дэмий юм байна гээд ёолсоор явжээ.

Гургалдайд атаархсан хэрээ




Холын холд алтан гургалдай, хэрээ хоёр амьдардаг байжээ. Алтан гургалдай баян айлын алтан торонд, харин хэрээ тэр айлын эсрэг талын модон дээр амьдардаг байж гэнэ. Гэрийн эзэн алтан гургалдайдаа маш их хайртай байлаа.



Түүнийг харж, асран юугаар ч дутаадаггүй байж гэнэ.

Бас заримдаа нартай сайхан өдөр салхилуулахаар цонхон дээр тавьдаг байлаа. Учир нь гургалдайн жиргэхийг хүмүүст сонсохыг хүсдэг байжээ. Гудамжаар өнгөрсөн хүмүүс

гургалдайн уянгалаг хоолойг шагшин магтдаг байлаа. Алтан гулгалдайн энэ байдлыг харсан хэрээ, өөрийн навсархай оромждоо үе үе санаа алдан суудаг байжээ. Нэг өдөр тэсэлгүй гургалдайд:




-Гургалдай найз минь, намайг чамд агаархаж байна гэж бүү бодоорой! Гэхдээ чи азтай шувуу юм аа! Чамд хүссэн бүхэн чинь байна. Чи юу хүссэнээ идэж байна. Чамд ямар ч зовлон байхгүй. Өөр юу хүсэх юм бэ! гэжээ. Алтан гургалдай:



-Хэрээ минь дээ, чамд л тэгж санагдаж байгаа юм. Дотор нь орж үзээгүй болохоор чи мэдэхгүй л дээ.

Намайг сайхан болохоор минь ингэж хайрлаж байна гэж чи бодож байна уу? Үгүй дээ! Энэ сайхан хоолой байгаагүй бол намайг нэг ч хором гэртээ байлгахгүй байсан юм. Би өсч

төрсөн нутгаасаа хол, энэ торонд хоригдон амьдарч байна даа гэж хариулжээ. Үүнийг сонссон хэрээ:



-За найз минь боль доо. Битгий маягла!

Над шиг халуунд халж, хүйтэнд хөрч үзсэн бол чи ингэж ярихгүй байсан юм! гэжээ. Гургалдай:

-Чи ингэж бодож байгаа юм бий вий! За яахав, чиний буруу бодож байгааг би баталж өгнө. Торонд амьдрах нь тийм ч сайхан биш гэдгийг чи ойлгоно оо! Миний амьдрал чиний төсөөлж байгаа шиг сайхан биш. Маргааш гэхэд би чамд үүнийг ойлгуулъя гэжээ. Өглөө нь гургалдай хэрээг дуудан:

-Хэрээ дүү минь, намайг сонсож бай! Одоо яваад өд сөд, хошуу, далавчаа минийх шиг болгоод ир! Тэгээд гэрийн үүдэнд шархтсан юм шиг дүр эсгэн хэвт. Эзэн маань чамайг өрөвдөн гэрт оруулна. Тэгээд торонд хийгээд надад хань болог гэсэндээ миний хажууд тавина. Харин чи дуугарч болохгүй шүү! Тэгвэл чиний хэрээ гэдгийг мэдчихнэ шүү! Мэдчихвэл шууд л хөөчихнө гэжээ.



Хэрээ гургалдайг анхааралтай сонсоод хэлсэн ёсоор нь гүйцэтгэжээ. Үнэхээр ч эзэн түүнийг өрөвдөн гэртээ оруулж, торонд хийгээд алтан гургалдайн дэргэд тавьжээ. Эхэндээ хэрээг донгодохгүй болохоор нь гэрийн эзэн, дасахаараа донгодох байх гэж боджээ.

Хоёр шувуугаа ижилхэн халамжилж байлаа. Эхний үед хэрээ ихэд сэтгэл хангалуун байв. Хэрээ, гургалдайд:

-Энд амьдрах уйтгартай хэцүү гээд байсан чинь яасан? Заавал нэг юм хийлгэж байж хариуд нь тэжээдэг гээд байсан чинь яалаа? гэж инээж байлаа.

Хэд хоног өнгөрлөө. Дураараа хашхирч гуагачих дуртай хэрээ уйдаж эхэллээ. Эзэн нь ч гэсэн донгодохгүй байгаад нь гайхаж эхлэв. Хэрээ нэг өдөр тэссэнгүй “Гуага, гуага” гэж гуагалж эхэлжээ. Эзэн, “Торонд уйдаж байгаа болохоороо гарах гэж ингэж дуугарч байна” гэж боджээ.

Хэрээ торонд хоригдсоор байгаад залхжээ. Хэрээ торноос гарахын тулд олон удаа гуагалсан

боловч эзэн нь түүнийг сайхан донгодохыг тэвчээртэй хүлээсээр л байлаа. Сүүлдээ үргэлж муухай дуу сонссоор байгаад залхан, тэвчээр алдарч торноос нь гарган хаяжээ.

Ингээд хэрээ торон доторх амьдралаасаа салж санаа амарчээ. Хуучин ноорхой үүрээ маш их санасан байжээ.

- Ноорхой ч гэсэн сайхан үүр минь дээ, үүр минь!



Чи минь ямар сайхан тайван амгалан юм бэ? Хатсан талх ч хамаагүй энэ үүрэндээ л идэж байвал хамгийн сайхан амттай юм байна.

Эрх дураараа нисч байгаад энэ үүрэндээ эргэн ирж амарсан нь хамгийн сайхан юм байна. Алтан гургалдайн зөв байжээ.



Аливаа зүйлд гаднаас нь харж дүгнэлт хийж болохгүй гэдгийг хэрээ мэдэж авлаа. Эрх чөлөө

Шиг сайхан зүйл байдаггүй юм байна гэж боджээ.

Ингээд эрх дураараа нисэн гуага гуага хэмээн гуагалдаг болжээ.



Худалч сармагчин



Эрт урьдын цагт нэгэн ойд нэг сармагчин амьдардаг байжээ. Тэр маш худалч юм гэнэ. Тийм учраас хэн ч түүний үгэнд итгэдэггүй, хэн ч түүнийг анхаарч сонсдоггүй байжээ. Худлаа ярьж амьтдыг сандруулсан үе түүнд цөөнгүй байв. Нэг өдөр өндөр модны орой дээрээс: “Анчид ирж явна!” гэж зарлан хашхирчээ. Үүнийг сонссон амьтад айж, сандран сүйд болсон ажээ.

Найзууд нь түүний энэ худалч занд дургүйлхэн түүнтэй найзлахаа больжээ. Угаасаа цөөхөн найзтай байсан сармагчин огт найзгүй үлджээ. Тэгсэн ч гэсэн тэр хашрахгүй л байлаа.


Сармагчин нэг өдөр ус уухаар цөөрөм дээр иржээ. Ус уучихаад яг буцах гэж байтал өөдөөс нь нэг өлсгөлөн матар амаа ангайсаар гараад ирэв. Сармагчин сандран зугатахыг оролдсон боловч чадсангүй. Тэгээд ч ойр хавьд нь авираад гарчихаар мод харагдсангүй. Айж цочсондоо болоод хөшчихжээ.

-Матар минь, замаас холдооч, би явмаар байна. Тэгээд ч амаа ингэж том битгий ангай! Би айгаад байна гэв.


Матар:

-Би яагаад замаас чинь холдох ёстой гэж? Би олон хоног ходоодондоо юм хийсэнгүй. Их өлсөж байна. Харин хоолоо уснаас биш, газраас оллоо. Тэгээд ч надад модны орой дээр дүүлдэг сармагчингийн мах идэх сайхан завшаан олддог байна шүү! гэж хэлээд шүлсээ гоожуулан сармагчинд ойртжээ. Сармагчин, матраас зугатах ямар ч боломжгүйг ойлгожээ.

-Ингээд үхдэг байжээ! Энэ матар үнэхээр намайг идэх юм байна. Бурхан минь, надад туслаач! Матрын амнаас аврагдах юм бол дахин хэзээ ч худлаа ярихгүй гэж залбирчээ.



Яг энэ үед ойд буун дуу гарахад матар айн цочжээ. Сармагчин энэ агшныг ашиглан, ухасхийн зугатаж амжив. Зугатаж байхдаа сармагчин, “Бурхан миний гуйлтыг зөвшөөрчээ. Бурхан минь танд баярлалаа.” гэж бодож амжив.



Бурхан гуйлтыг нь биелүүлсэнд сармагчин маш их талархсан ч гэсэн өөрийн амлалтыг таг мартжээ. “Сурсан юмыг сураар боож болдоггүй” гэдэг шүү дээ. Нөгөө сармагчин маань хуучин зангаа орхилгүй худлаа ярьсаар л байлаа. Засрах нь бүү хэл улам их худлаа ярьж эхэлжээ. Нэг өдөр модон дээр суун ганцаараа ярьж байлаа.

Түүнд нэг ч найз үлдээгүй учир тэр ийнхүү өөрөө өөртэйгээ ярьдаг болжээ.

Яг энэ үед сууж байсан модон доогуур нь нэгэн арслан өнгөрч байгааг харжээ.

-Энэ арсланг би айлгаж чадна. Бүр айсандаа болоод эргэж ч харалгүй зугатна.

Хэрэв үүнийг хийж чадахгүй бол дахиж хэзээ ч худлаа ярихгүй гэж бувгнажээ. Ингээд доош буун арслангийн урд зогсон:

-Арслан ах минь! Би сая өндөр модны орой дээрээс ойд их том түймэр гарч байхыг харлаа. Түймрийн гал юу юугүй нааш ирэх нь хурдан зугатаарай! гэлээ.

Арслан тэр өдөр маш их ууртай байлаа.

-Аа муу хар худалч! Түймэр гарч байгаа юм бол модны орой дээрээс бүх амьтдад зарлахгүй яасан юм бэ? Мэдээж чамд хэн итгэхэв дээ! Чи муу худалч гээд сармагчинг нэг сайн алгаджээ. Сармагчин зугатан хажуу тийш болсон учир арслангийн савар түүний сүүлийг гэмтээжээ.

Сүүлээ гэмтээсэн сармагчин зугатаж байхдаа өвдсөндөө ёолон:

-Энэ худалч зан уу, үүнээс болж найз нөхөдгүй болсон. Би харин энэ зангаасаа сургамж авахын оронд улам их дэггүйтсэн.



Эцэст нь сүүлгүй болох шахлаа гэж байлаа. Сармагчин энэ өдрөөс хойш огт худал хэлээгүй бөгөөд үнэнч нэгэн болсон гэдгээ маш олон жил оролдож байж бусдад итгүүлжээ.



Table of Contents

[Чонын зөрүүд зан](#)

[Гургалдайд атаархсан хэрээ](#)

[Худалч сармагчин](#)